

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
БИЗНЕС ЭРХЛЭЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.БААСАНСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Аймгийн бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	1.1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Эрдэнэт хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэх, тайлагнах	-Хэрэгжилтийн хувь	90.0 хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эрдэнэт шинжлэх ухаан технологийн салбарын чиглэл, хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэлэг, стандарт хэмжил зүйн чиглэлээр 14 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдаж 95.9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд шинжлэх ухаан технологи, хүнс, хөдөө аж ахуй, стандарт, малын эрүүл мэнд чиглэлээр 7 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг тусган ажиллаж 96.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Орхон аймаг, Эрдэнэт хотын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд салбарын чиглэлээр 34 арга хэмжээ тусган 95.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.	2024.01.02 2024.12.31	100%
2.	1.2.Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ын Зөвлөлийн Хуралдаанд холбогдох асуудлуудыг хэлэлцүүлэх	Холбогдох асуудлуудыг 100 хувь хэлэлцүүлсэн байна.	100.0 хувь	Холбогдох асуудлуудыг хугацаанд нь 100 хувь хэлэлцүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөө, аймгийн 2024-2025 оны хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө, “Өрхийн тариалалтыг дэмжих” хөтөлбөрийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрдэнэт ШУТП-ийн 2023 оны ажлын тайлан, 2024 оны ажлын төлөвлөгөө, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон	2024.01.02 2024.12.31	100%

					аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийн сангуудын зээлийн хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлсэн. Аймгийн ИТХ-ын зөвлөл, ээлжит болон ээлжит бус хуралдаанаар 2024 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан 2024-2025 оны Эрдэнэт хотын болон Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2024 оны 19/03 дугаар тогтоолоор батлуулсан. Тус төлөвлөгөөнд мал аж ахуйн чиглэлээр 12, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чиглэлээр 4, газар тариалангийн чиглэлээр 11, хүнсний чиглэлээр 1, нийт 28 арга хэмжээ тусгагдаж явцын тайланг аймгийн ИТХ-ын Зөвлөлийн Хурлаар хэлэлцүүлсэн. Мал эмнэлгийн газраас орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив батлуулах төслийг аймгийн ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлж аймгийн ИТХ-ын зөвлөл, аймгийн ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлсэн.		
3.	1.3.ХХААХҮСайд, Орхон аймгийн Засаг даргын нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах	Гэрээний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувь ханган ажилласан.	Гэрээний хэрэгжилтийг 97.3 хувь ханган ажилласан.	-	ХХААХҮСайд, Орхон аймгийн Засаг даргын нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, бусад чиглэлээр тусгагдсан нийт 38 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, 97.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.	2024.01.02 2024.12.31	100%
4.	1.4."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувь ханган ажилласан байна.	85.7 хувь	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулж, 23 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ онд тус төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулалтын 12 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 107.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж ажилласан. Аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 73.6 хувь, сүүний 8.3 хувь, цагаан идээний 7.1 хувь, гурилын 3.6 хувь, гурилан бүтээгдэхүүний 59.2 хувь, төмсний 51.6 хувь,	2024.01.02 2024.12.31	100%

217

					хүнсний ногооны 100 хувь, өндөгний 1.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгосон хүүгийн хөнгөлөлттэй зээлээс хиам, талх үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нарийн боов, бялууны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 277.0 сая төгрөгийн зээл тус тус авч, бялуун төрлийн бүтээгдэхүүний 1 аж ахуйн нэгж шинээр нэмэгдсэн. Аймгийн хүн амын 2024 оны хаврын махны хэрэгцээний 21.6 хувь буюу 200 тн махыг Эрдмийт ХХК, Жаргалант мах импекс ХХК-иуд бэлтгэн хаврын улиралд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2024" нэгдсэн арга хэмжээнд хүнс, хөдөө аж ахуйн 10 үйлдвэрлэгчийг дэмжин оролцуулав. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр Хантай баян ХХК халтар арвайн гурил, Ачит андага ХХК артишок цай, 2 төрлийн жүүс, артишок шимийн архи, Баярмөнх наран ХХК эрүүл мэндийн цай, Эрдэнэт ногоон нүүдэл ХХК грек бяслаг, шар сүүний цэлцэгнүүр, тус компанитай хамтран ажиллагч 1 малчин уламжлалт аргаар бэлтгэсэн цагаан идээ, газар тариалангийн чиглэлээр Жаргалант, Баян-Өндөр сумын 6 тариаланч 11 төрлийн 20 тн төмс, хүнсний ногоогоор оролцож, нийт 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. "Өвлийн идэш" арга хэмжээнд Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн давхардсан тоогоор 35 иргэн, хоршоо оролцож нийт 32.3 тонн мах худалдан борлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 91.7 хувь байна.		
5.	1.5."Малын эрүүл мэнд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	96.8 хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувь	"Малын эрүүл мэнд" хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөнд 9 зорилт, 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан. 2024 онд халдварт, архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 11 төрлийн вакцин тарилгад 155.7 мянган толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн 146.5 мянган толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 94.0 хувь, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 210.4 мянган толгой мал, амьтан	2024.01.02 2024.12.31	100%

					хамруулахаар төлөвлөж мал угаалгад 88.0 мянган толгой, боловсруулалтад 60.0 мянган толгой, туулгалтад 62.4 мянган толгой мал хамруулж 100 хувь хэрэгжсэн. Малын бруцеллэзтой тэмцэх стратеги, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2024 онд дархлаажуулалтад хамрагдах бод 8.0, бог 24.0 мянган малын охин төл, нийт 32.0 мянган төл мал хамруулахаар вакцины захиалга хийгдэж 32.0 толгой малыг дархлаажуулалтад бүрэн хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. Тус онд нийт 5468 малын сэг, зэм цуглуулж, 2 цэгт булж устган, устгалын талбай болон бэлчээрийн 565.8 мян/мкв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийгдэж, сэг зэм устгалын ажил аймгийн хэмжээнд 100 хувь хийгдсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд мал, амьтны халдварт өвчнөөр эрүүл, тайван байдлыг хадгалсан.		
6.	1.6.Холбогдох ажлын хэсэг байгуулах, ажлын хэсэгт ажиллах	Ажлын хэсэгт орж ажилласан байна.	6 ажлын хэсэгт ажилласан.	Холбогдох ажлын хэсэгт орж ажилласан байна.	Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг, хүн амын хаврын хэрэгцээнд бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжийн худалдаанд нийлүүлж буй маханд хяналт тавих, "Гарааны бизнес-2024" төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт зохион байгуулах ажлын хэсэг, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тусгай зориулалтын сангаас зээл олгох ажлын хэсэг, хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг хүлээн авах ажлын хэсэг, "Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" нэвтрүүлэх ажлыг төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах зэрэг 6 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.	2024.01.02 2024.12.31	100%
7.	1.7.Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах	Хүн амын хаврын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн борлуулах, хяналт тавих	Гэрээ байгуулан ажилласан.	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Аймгийн хүн амын 2024 оны хаврын махны хэрэгцээний 21.6 хувь буюу 200 тн махыг Эрдмийт ХХК, Жаргалант мах импекс ХХК-иуд бэлтгэн хаврын улиралд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэн ажилласан. "Өвлийн идэш" арга хэмжээнд Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн давхардсан тоогоор 35 иргэн, хоршоо оролцож нийт 32.3 тонн мах худалдан	2024.01.02 2024.12.31	90%

219

		ажлыг зохион байгуулсан.			борлуулсан. Аймгийн хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах зарыг www.erdenet.mn, hhaag.erdenet.mn сайт, байгууллагын фэйж хуудас, Монголын өдөр тутмын сонин "Өглөөний сонин"-д нийтэлснээр 3 аж ахуйн нэгж материал ирүүлээд байна. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурал болохоор төлөвлөж байна.		
8.	1.8.Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	-Хамтран ажилласан байгууллагын тоо	Тогоочдын холбоо ГҮТББ, Оёдолчдын холбоо, Эрдэнэт хот орчмын фермерүүдийн холбоо, Хүнсчдийн холбоо болон Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран ажилласан.	Хамтран ажилласан байна.	Салбарын чиглэлээр холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд Тогоочдын холбоо ГҮТББ-тай 5.0 сая, ХЭАХН-тэй 2.0 сая, ХААХХ ТББ-тай холбогдох чиглэлээр хамтран ажиллахаар 2.0 сая төгрөгийн санхүүжилттэй гэрээ тус тус байгуулан ажиллав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгуудын Засаг дарга нартай байгуулсан 2024 оны гэрээнд "Орон нутгийн онцлог бүхий уламжлалт брэнд хоол, идээ ундааг шинээр бий болгох, хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар тусгасны дагуу монгол үндэсний хоол, идээ ундааны "Улсын аварга тогооч" шалгаруулах анхдугаар уралдааныг 7 төрөлд, Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажиллагсдын спортын анхдугаар наадмыг 5 төрөлд явуулж, 18 аймаг, 7 дүүргийн нийт 700 гаруй салбарын ажиллагсад оролцож, 58 шагналт байрыг эзлүүлэн шагнаж урамшуулсан. Үр дүнд орон нутаг анх удаа тогооч нарын улсын зэрэглэлтэй арга хэмжээг амжилттай зохион байгуулж, 426 тогоочийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн харилцан туршлага судлуулсан. Шинэ жилийн баярын үйл ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэхэд "Номын шидэт хайрцаг" ТББ-тай хамтран аймгийн иргэд, хүүхэд багачуудад шинэ жилийн баярын үйл ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэхэд дурсамж үлдээх зорилгоор халуун хоол, уух зүйлс, бэлэг дурсгалын зүйл худалдаалж, хүүхдүүдэд өвлийн өвгөн, Пони морьтой үйлчилгээ үзүүлж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэн орон нутгийн	2024.01.02 2024.12.31	100%

2024

					онцлог бүтээгдэхүүнийг сурталчлан ажилласан. Хөгжлийн шийдэл ТББ-ын "BEST" хөтөлбөртэй хамтран хүнсний үйлдвэрлэл, оёдлын үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, хоршооны салбарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан салбар тус бүрт 11-18 удаагийн багц сургалт зохион байгуулан амжилттай оролцсон аж ахуйн төлөөлөлд "Сертификат" гардуулсан. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин бараа, бүтээгдэхүүнийг сурталчилах, олон нийтэд таниулах, харилцан туршлага судлуулах зорилгоор "Хойд бүсийн түншлэл-2024" үзэсгэлэн худалдаа, Гар урлаачдын "Уран гар-2024" бүтээлийн уралдаан зэрэг нэгдсэн арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд "Хангарди палас"-т зохион байгуулж, Орхон, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нийт 150 орчим үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн, урласан 978 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 89.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.		
9.	1.9.Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах	-Хамтран ажилласан байгууллагын тоо	Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн GIZ-PROGRESS төсөл, "Хөгжлийн шийдэл" Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөртэй хамтран ажилласан.	Хамтран ажилласан байна.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл, хөтөлбөрүүдтэй холбогдох чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүнд: Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрхзүйн мэдлэг, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 1 сарын хөтөлбөрт сургалтыг Best хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийн ажилтнуудыг 5 удаагийн сургалтад хамруулан мэдлэг олгон сертификатжуулсан. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олголтыг хялбарчлах зорилгоор "Хөгжлийн шийдэл" ТББ-ын "BEST" хөтөлбөртэй хамтран холбогдох төрийн байгууллагууд, банкуудыг оролцуулан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсны дүнд аймгийн Засаг даргын 2024 оны А/145 дугаар захирамжаар журмыг шинэчлэн батлуулсан.	2024.01.02 2024.12.31	100%

100%

10.	1.10.Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлээр ажиллах 90-ээс доошгүй хувиар хангасан байна.	99.6 хувь	Холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын 28 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ жил аймгийн аюулгүйн нөөцөд өвс 200 тн, тэжээл 86.1тн буюу аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг 100 хувь бүрдүүлсэн. Аймгийн Онцгой комиссын зардлаас 296.0 сая төгрөгөөр өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд нэмэлтээр 2000 боодол буюу 40 тн өвс, 7142 шуудай буюу 178.5 тн тэжээл, 600 кг био бэлдмэл, 1670 ширхэг долооцыг нөөцөд бэлтгэн нэг малчин өрхөд 8-15 боодол өвс, 5-8 шуудай хивэг, 2-3 ширхэг долооц, 1 кг био бэлдмэлийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн ИТХ-ын 2024 оны 19/03 дугаар тогтоолоор хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг батлуулсан. Тус төлөвлөгөөнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар 12, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чиглэлээр 4, газар тариалангийн бэлтгэл хангах талаар 11, хүнсний чиглэлээр 1, нийт 28 арга хэмжээ тусган ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилт 98.1 хувь байна. 2024 онд орон нутгийн төсвийн 195.0 сая төгрөгөөр аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 60 тн өвс, 25.0 тн тэжээл, Жаргалант сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 30 тн тэжээл, Баян-Өндөр суманд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвс, 20 тн тэжээл, нийт 160 тн өвс, 75.0 тн тэжээл тус тус бэлтгэсэн. Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн төсөвт 58.6 сая төгрөг тусган, 4 төрлийн дархлаажуулалтад 54.6 мянган толгой мал хамруулахаас 52.7 мянган толгой мал хамруулж гүйцэтгэл 96.5 хувь явагдаж байна. Аймгийн хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах зарыг www.erdenet.mn, hhaag.erdenet.mn сайт, байгууллагын фэйж хуудас, Монголын өдөр тутмын сонин "Өглөөний сонин"-д нийтэлснээр 3 аж ахуйн нэгж материал ирүүлээд байна. Сонгон	2024.01.02 2024.12.31	100%
-----	---	-----------	---	--	--------------------------	------

					шалгаруулах ажлын хэсгийн хурал болохоор төлөвлөж байна. 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд танилцуулсан.		
11.	1.11.Өрхийн үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллах	-Дэмжин ажилласан өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо		Холбогдох арга хэмжээг авч дэмжин ажилласан байна.	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2023, 2024 онд тус бүр 20.0 сая төгрөг батлагдсан. 2024 онд “Шинэ хөдөө-Орхон” төслийн хүрээнд 17 нэр төрлийн 29 тоног төхөөрөмж, 100 ширхэг хүлэмжийг өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд гэрээгээр эзэмшүүлсэн. Аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тусгай сангаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. 2024 онд өрхийн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг 3 удаа зохион байгуулж бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжсэн. Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, өдөрлөг, арга хэмжээг А.Амарын талбайд зохион байгуулж, үндэсний хувцас, эсгий гар урлалын бүтээгдэхүүн, эрүүл мэндийн цай үйлдвэрлэл, шүрэн эдлэл, арьсан эдлэл, төмөр хийц, уран дархан мужаан, эко саван үйлдвэрлэл, уран зураг, бичлэг зэрэг өрхийн болон жижиг дунд бизнес эрхэлдэг 44 иргэн, аж ахуй нэгж оролцож, 37.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2024” үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр Хантай баян ХХК халтар арвайн гурил, Ачит андага ХХК артишок цай, 2 төрлийн жүүс, артишок шимийн архи, Баярмөнх наран ХХК эрүүл мэндийн цай, Эрдэнэт ногоон нүүдэл ХХК грек бяслаг, шар сүүний цэлцэгнүүр, тус компанитай хамтран ажиллагч 1 малчин уламжлалт аргаар бэлтгэсэн цагаан идээ, газар тариалангийн чиглэлээр Жаргалант, Баян-Өндөр сумдын 6 тариаланч 11 төрлийн 20 тн төмс, хүнсний ногоогоор оролцож, нийт 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин бараа, бүтээгдэхүүнийг сурталчилах, олон нийтэд таниулах, харилцан туршлага судлуулах зорилгоор “Хойд бүсийн	2024.01.02 2024.12.31	90%

2023

					түншлэл-2024" үзэсгэлэн худалдаа, Гар урлаачдын "Уран гар-2024" бүтээлийн уралдаан зэрэг нэгдсэн арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд "Хангарди палас"-т зохион байгуулж, Орхон, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нийт 150 орчим үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн, урласан 978 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 89.0 сая төгрөгийн борлуулалт хийсэ байна.		
12.	1.12.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл хүссэн өргөдөл, материалыг хүлээн авах, арилжааны банкуудад уламжлах	-Хүлээн авсан төслийн тоо -Дэмжсэн төслийн тоо	Аймгийн ЖДҮ сангаас 5 зээл олгогдсон.	Зээл хүссэн өргөдлийг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж холбогдох газарт хүргүүлсэн байна.	"Орхон аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам", "Хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргах ажлын хэсэг"-ийн аймгийн Засаг даргын 2024 оны А/145 дугаар захирамжаар батлуулсан. Жижиг, дунд болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ХААН, Капитрон, Төрийн банктai байгуулсан гэрээний хугацаа дууссантай холбогдуулан гэрээ сунгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр гэрээний төсөл, журмын хамт хүргүүлснээр ХААН, Капитрон банкууд гэрээг 5 жилийн хугацаатайгаар сунгасан. Аймгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих сангаас зээл хүссэн хүсэлтүүдийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон.	2024.01.02 2024.12.31	100%
13.	1.13.Согтууруулах ундаа худалдах, үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээн авч ажлын хэсэгт танилцуулах, холбогдох шийдвэрийг аж ахуйн нэгжүүдэд хүргэх	-Хүлээн авсан хүсэлтийн тоо	Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлтийг мэдээлсэн.	Хүсэлтийг шийдвэрлэн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар согтууруулах ундаа худалдах 320, үйлчлэх 112, нийт 432 цэг байсан. Тайлант хугацаанд худалдах, үйлчлэх 39 тусгай зөвшөөрөл шинээр олгосоноор цэгийн тоо 470 хүрсэн. Зургаан сараас дээш хугацаагаар тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулаагүй 69 цэгийн тусгай зөвшөөрлийг цуцалсан. Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр ханган ажиллаж байна. ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар	2024.01.02 2024.12.31	100%

2024

					согтууруулах ундаа худалдах, үйчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах шаардлага батлагдсантай холбогдуулан холбогдох хууль, тогтоомж, тушаал, бүрдүүлэх материалын талаар аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл тогтмол өгч холбогдох байгууллагуудын хамт 4 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 400 хүнд мэдээлэл өгсөн. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг https://e-business.mn/ системээр хүлээж авч, ажлын хэсгийн хурлыг 11 удаа хийж, тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдээр улсын тэмдэгтийн хураамж төлүүлэн, тусгай зөвшөөрлийг цахимаар хүргэж байна.		
14.	1.14.Худалдаа, үйлчилгээ эрхлэгчидтэй холбогдох чиглэлээр хамтран ажиллах	-Хамтран хэрэгжүүлсэн ажлын тоо	Холбогдох чиглэлээр хамтран ажилласан.	Холбогдох чиглэлээр хамтран ажилласан байна.	Баян наадмын Худалдаа, тээвэр үйлчилгээний асуудал эрхэлсэн комисст ажилласан. 2024 онд үйлдвэрлэл эрхлэгчдийг 4 удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцуулж бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжсэн. “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр оролцсон. Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, өдөрлөг, арга хэмжээг А.Амарын талбайд зохион байгуулж, өрхийн болон жижиг дунд бизнес эрхэлдэг 44 иргэн, аж ахуй нэгж оролцож, 37.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2024” үзэсгэлэн худалдаанд 11 иргэн, аж ахуйн нэгж оролцож нийт 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Хойд бүсийн түншлэл-2024” үзэсгэлэн худалдаа, Гар урлаачдын “Уран гар-2024” бүтээлийн уралдаан зэрэг нэгдсэн арга хэмжээнд хойд бүсийн 150 орчим үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн, урласан 978 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 89.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	2024.01.02 2024.12.31	100%

2025

15.	1.15.Салбарын чиглэлээр иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх	Өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн хувь	41 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн.	Өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.	Тайлант хугацаанд худалдаа үйлчилгээний чиглэлээр болон тоног төхөөрөмж, хүлэмж, хөнгөлөлттэй зээл, согтууруулах ундааны үйлчилгээний газартай холбоотой гаргасан 30 өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Удирдлагаас ирүүлсэн 40 үүрэг даалгаврын биелэлт 95.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант хугацаанд салбарын чиглэлээр 92 бичиг хүлээн авч, 133 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 52 захирамж төлөвлөн гаргасан.	2024.01.02 2024.12.31	100%
Зорилт 2. "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	2.1.Салбарын хууль, бусад хууль, тогтоомж, шийдвэрийг үндэслэн захирамж, шийдвэрийн төсөл боловсруулах	-Захирамж, шийдвэрийн тоо	Захирамжийн 55 төсөл боловсруулан ажилласан.	Захирамжийн биелэлтийг ханган ажилласан байна.	Тайлант хугацаанд 52 захирамж боловсруулан ажилласан.	2024.01.02 2024.12.31	100%
2.	2.2.Салбарын чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах	-Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо, биелэлт	Салбарын чиглэлээр 77 үүрэг даалгаврын биелэлтийг хангасан.	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн ажилласан байна.	Тайлант хугацаанд салбарт холбогдох чиглэлээр удирдлагаас өгсөн 40 үүрэг даалгаврын биелэлт 95.8 хувийн гүйцэтгэлтэй байна.	2024.01.02 2024.12.31	95.8%
Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	3.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, шаардлагатай мэдээллийг хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэх	Биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн.	Биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүр, бусад тайланг тайлант хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	2024.01.02 2024.12.31	100%
2.	3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг	Хууль тогтоомжийг биелүүлэн ажиллана.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31	100%

999

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.						
---	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Холбогдох бичиг баримтуудыг архивт хүлээлгэн өгөх	Архивт хүлээлгэн өгсөн байна.	Холбогдох бичиг баримтуудыг архивт хүлээлгэн өгсөн.	Архивт хүлээлгэн өгсөн байна.	Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой 2023 оны бичиг баримтуудыг архивт хүлээлгэн өгсөн. 2024 онд хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байгаа бөгөөд эдгээр бичиг баримтыг цахим хэлбэрээр хадгалж байна.	2024.01.02 2024.12.31	100%

Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		
Зорилт 1.								
1.	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулах	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна.	Холбогдох хууль тогтоомжийг судласан.	Холбогдох хууль тогтоомжийг судлан мэдлэгээ сайжруулна.	Согтууруулах ундаа худалдах, үйлчлэхтэй холбоотой батлагдан гарсан хууль тогтоомж болон салбарын чиглэлийн, төрийн албаны, бусад холбогдох хууль тогтоомж шийдвэрийг судалж ажиллаж байна. Удирдлагын академийн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго зорилтыг таниулах сургалт, Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт, үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Монгол улсын ТА3-өөс долоо хоног бүрийн 4 дэх өдөр зохион байгуулдаг 7:4:10 сургалтад тогтмол хамрагдаж байна.		100%	
2.	Холбогдох хурал, зөвлөгөөн, сургалтад хамрагдах	-Хамрагдсан сургалтын тоо	Холбогдох мэдээлэл авсан.	Холбогдох хурал, зөвлөгөөн,	ТАС3 болон салбарын чиглэлээр зохион байгуулсан 8 удаагийн сургалтад хамрагдсан. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий 2024 оны 04 сарын 26-ний өдрийн		100%	

2024

				сургалтад хамрагдаж мэдээлэл авна.	нээлтийн арга хэмжээнд аймгийн 72 төлөөлөгчийн хамт оролцсон. Тус арга хэмжээн нь Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд 21 аймгийн 300 сумын 3100 гаруй төлөөлөгч оролцож "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий зорилго, хоршоонд нэгдэхийн ач холбогдол, хоршоо байгуулах, бүртгүүлэх, хэрхэн элсэх талаар зөвлөмж, хоршооны сайн туршлагуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Булган аймагт 06/06-ны өдөр зохион байгуулагдсан Шинэ хоршоо хөдөлгөөний сургалтад аймгийн 25 хоршоодын төлөөллийн хамт оролцов.		
3.	Үндэсний бичгийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан.	Сургалтанд хамрагдсан байна.	ХБТХОХ-ийн мэргэжилтнүүд 14-р сургуулийн монгол хэл бичгийн багшаас үндэсний бичгийн сургалт авсан. Мөн Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан үндэсний бичгийн дунд шатны сургалтад хамрагдсан.		100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ, БИЗНЕС ЭРХЛЭЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.БААСАНСҮРЭН